



Оройн Дээд Цагаан Лянхуа Судар

Гэгээн Хутагт Рид Хувилгааныг Үзүүлсэн нь хэмээх 21-р бүлэг

“Насад Зэвүүцэхгүй Бодисадва” бүлгийн төгсгөлд “Бурханы нөгчсөн цагт энэхүү нандин сургаалыг сонсох боломж гарвал огтхон ч эргэлзэж үл болно. Заавал чин сэтгэлээсээ сургаалыг айлдаж түгээгтүн. Тэгвэл тэр буяны ачаар дараа төрөлдөө бурхантай уулзаж, ямар ч саад барцадгүй бурханы гэгээрлийг олох болмой” гэж Шагжамүни будда айлдана. Үүнийг сонссон газраас хөөрөн гарч ирсэн тоолшгүй олон бодисадва нар Шагжамүни буддаг нирваан болсны дараа энэ судрыг заавал айлдан түгээх болно гэдгээ тангараглав. Шагжамүни будда сэтгэл амарсан бололтой аажуухан толгой дохиод, гайхамшигт Арван хувилгаан хүчийг үзүүлнэ. Улмаар Дээд үйл бодисадва тэргүүтэй бусад бодисадва нар болон цугласан олон уруу харж ийнхүү айлдана. “Бурханы хувилгаан хүч сая үзүүлсэн шиг хязгааргүй бөгөөд төсөөлөхийн аргагүй агуу гайхамшигтай билээ. Гэвч Цагаан Лянхуа Сударын ач буян бүр илүү агуу болой. Намайг нөгчсөний дараа энэхүү Цагаан Лянхуа Сударыг түгээгтүн хэмээн Түүнчлэн ирсэн хязгааргүй хувилгаан хүчийг үзүүлж тэр буяны ач ямар болохыг айлдлаа ч, бүгдийг айлдаж үл дуусна. Яагаад гэвэл Цагаан Лянхуа Судар нь Түүнчлэн ирсний гэгээрсэн ертөнцийн бүх хууль, Түүнчлэн ирсний уян хатан, эрх чөлөөт хүч чадвар, Түүнчлэн ирсний дотор хязгааргүй байх бүхий л сургаал болон хамаг амьтныг аврахын тулд хийсэн хамаг үйл, эдгээрийг бүгдийг нь өөртөө багтаасан байдаг болохоор билээ.” Ийнхүү Шагжамүни будда Цагаан Лянхуа Сударын хэмжээлшгүй нандин үнэ цэнэ, сургаал нь төгс төгөлдөр болохыг гэрчлээд, Түүнчлэн ирснийг нөгчсөний дараа ямар сэтгэлийн бэлтгэлтэй байхыг айлдана.

“Иймийн тулд намайг нөгчсөний дараа, энэхүү сургаалыг чин сэтгэлээсээ өөрийн болгож, уншиж, тогтоож, айлдаж, хуулан бичиж, сургаалыг тэр чигээр нь хэрэгжүүлэхгүй бол болохгүй. Түүнчлэн та бүхний байгаа газарт сургаалыг өөрийн болгож, уншиж, тогтоож, айлдаж, хуулан бичиж,

сургаалыг зөв хэрэгжүүлж байх аваас тэнд суврага бүтээж, тэр сургаалыг хүндлэн тахигтун. Яагаад гэвэл тэр газар миний гэгээрэлд хүрсэн газраас өөрцгүй билээ. Мөн Цагаан Лянхуа Сударыг чин сэтгэлээсээ өөрийн болгож, амьдралдаа хэрэгжүүлж буй газар нь бурхад дээдийн оюун ухааныг гэгээрсэн газар, бурхадын сургаал үүрд орших газар, бурхад нирваан болох газар гэсэн үг юм.”

Ингээд эцэст нь ийнхүү айлдана.

“Түүнчлэн ирснийг нөгчсөний дараа бурхан яагаад сургаал айлдсан, ямар хүнд, хаана айлдсан болох, айлдсанаар ямар үр дүнд хүрсэн болохыг тодорхой мэдсэний үндсэн дээр сургаалыг хүмүүст алдаагүй айлдвасаас нар, сарны гэрэл харанхуйг гийгүүлэх мэт хүмүүс мунхагийн харанхуйгаас ангижирах болой. Ингэж сүсэгтэн олныг Нэг хөлгөнд оруулж чадах болмой. Тиймээс энэхүү сургаалын ач буян ямар гайхамшигтай болохыг сонссон хүн бурханыг нөгчсөний дараа энэ сургаалыг өөрийн болгож, бурханы гэгээрэлд хүрэх хүсэл эрмэлзлэлтэй болж, эргэлзээгүй бурханы зам мөрөөр алхах болой.”



Чин сэтгэлээсээ залбирах нь

Цагаан Лянхуа Сударт олон бодисадва нар гарч ирдэг. Тэдгээрийн дундаас Арьяавал бодисадваг хүмүүс хамгийн сайн мэддэг билээ. Арьяавал бодисадва нь бодит амьдрал дээр зовж байгаа хүмүүсийн дууг сонсоод, янз бүрийн дүр хэлбэрээр хувилан гарч ирж хүмүүсийг авардаг гэгддэг. Арьяавал бодисадвагийн бүхийгээс үүдэн хэмээх бүлэгт “нигүүлсэхүйн нүдтэн” гэж гардаг. Энэ нь нигүүлсэхүйн нүдээр хүмүүсийг харж байдаг Арьяавал бодисадва нь хүмүүс бидний үлгэр дууриал болдог ба үүнийг бодит амьдрал дээр тайлбарлах юм бол “жинхэнэ нөхөрлөл, энэрэл, нэгэн сэтгэл”-тэй байх гэсэн үг болох биз ээ.

Гэвч уржинан жилийн Японы зүүн хэсэгт болсон газар хөдлөлт шиг зүйл тохиолдоход бид яахаа ч мэдэхгүй аргаа бардаг. Өөрөө ч амсаж үзээгүй зовлонг хэрхэн хүлээн авч, зовж шаналж буй хүмүүсийн сэтгэлд хэрхэн ойртож, хэрхэн хамтдаа урагшаа алхах вэ гэдгийг би тэр үед эргэцүүлэн бодсон юм. Тэр өдрөөс хойш олон хүн “би юугаар тусалж чадах вэ?” гэсэн энэрэнгүй үйлийн тухай эргэцүүлэн бодох болсон байх.

“Хайрын эсрэг сэтгэл бол үзэх ядах явдал биш үл тоомсорлох явдал” гэсэн үг байдаг. Өөрөөр хэлбэл бусдаас тасархай, ганцаардмал байна гэдэг хайр энэрэл байхгүй байна гэсэн үг. Тийм ч учраас зовж буй хүмүүсийг марталгүй дурсан санаж, зовлон бэрхшээл нь бага ч болов



нимгэрэх болоосой гэж чин сэтгэлээсээ залбирах нь тэдгээр хүмүүсийн сэтгэлийг ойлгож байна гэсэн үг бөгөөд энэ нь энэрэнгүйн үйл болно.

Бодит тусламж үзүүлж, түүнийгээ үргэлжлүүлэх нь мэдээж хэрэг чухал. Гэвч жишээ нь санасны дагуу сайн дурын үйл ажиллагаа явуулж, санхүүгийн тусламж үзүүлж чадахгүй байсан ч зовж буй хүмүүсийн сайн сайхны төлөө залбирч, мөргөх нь хэн ч хийж чадах энэрэнгүйн үйл билээ.

Халуун дулаан уур амьсгалыг дэлгэрүүлэх нь

Зовж байгаа хүнийг хараад бид “яаж ийж байгаад туслах юмсан” хэмээн чадах чинээгээрээ туслахыг боддог. Энэ нь хэнд ч байдаг нигүүлсэхүйн сэтгэл бөгөөд үүнийг өөрөөр тайлбарлавал “бусдын ачаар амьдарч байгаадаа талархан, хариу тус хүргэх” явдал ч гэж хэлж болно.

Энэ ертөнц гэдэг маш олон үзэгдлүүд хоорондоо тор шиг хэлхэлдсэн байдаг “ач тусын ертөнц” юм. Амьтай бүхэн хэн нэгний ач тусын буянаар амьдарч байдаг. Ингээд бодохоор бид бусдыг энэрэн нигүүлсэж, өөрт байгаа зүйлээ өгөх нь агуу их ач буяны өчүүхэн хариу болно гэж хэлж болох биз ээ.

Бид хүнд туслая гэхээр сэтгэл нэг л хүнд оргих үе байдаг. Улмаар өөрийгөө юугаар ч тус болж чадахгүй юм байна гэж бодон сэтгэлээр унадаг. Тиймээс бусдад туслахдаа ивээж, тусалж ирсэн олон зүйлийн ачийг хариулж байна гэж бодон сэтгэлээр уналгүй, өөрийн хийх ёстой мэдээжийн зүйлийг хийж байна гэж бодох хэрэгтэй.

Ер нь бол бид бүгд нэгэн бүхэл Агуу Их Амийг бүрдүүлж байдаг ах, эгч дүүс билээ. Энэ утгаараа бид хоорондоо би, чи

гэсэн ялгаа байхгүй бөгөөд хэдийн хамтдаа нэгэн замаар алхаж буй нэг л амь юм.

Бидний тусалж чадах зүйл өчүүхэн жижигхэн зүйл байж магадгүй. Гэвч хүний амь насны эх үндсийг бодоод үзэх юм бол өчүүхэн зүйл байж магадгүй ч, хүний төлөө, нийгмийн төлөө залбирах сэтгэл нь их том тус дэм болдог. Гэр бүлээ хайрлах хайр нь олон хүний сэтгэлийг дулаацуулах эх үндэс болдог. “Хүмүүсийг аварч, нийгмийг засан төвхнүүлэх” гэсэн манай нийгэмлэгийн эх үүсвэрийн уг санаанаас бодоод үзэхэд ч, гишүүний тангарагт “гэр бүл, нийгэм, улс ...” гэж бичсэн байдагчилан бидний өдөр тутмын энэрэнгүй сэтгэл ба үйл нь нийгэмд халуун дулаан уур амьсгалыг дэлгэрүүлэх чухал хүчин зүйл болдог билээ.

Энэрэнгүй сэтгэл гарч ирнэ гэдэг нь түүнийг үүсгэх Арьяавал Бодисадва байдаг учраас юм. Тэр Арьяавал Бодисадва нь гэр бүл, найз нөхөд, эсвэл зурагтаар гарч байгаа хэн нэгэн хүн байж ч магадгүй. Янз бүрийн дүр төрхөөр бидний өмнө гарч ирж байдаг Арьяавал Бодисадвагаас оюун ухаан ба энэрэнгүй сэтгэлийг суралцах нь “нэгэн замаар хамтдаа алхах” гэсэн үг болов уу.

“Косэй” сэтгүүл, 2013 оны 3 сарын дугаараас



Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

**Рисшо Косей Кайгийн Удаах Ерөнхийлөгч
Нивано Коошёо**

Ил захидлаар дамжуулах чин сэтгэл

Хэдэн жилийн өмнө болсон явдал. Оны эцэс дөхөж байсан нэгэн үдэш охин маань ингэж хэлэв:

- “Би лав гашуудлын ил захидал явуулахгүй ээ. Энэ чинь шинэ жилийн ил захидал ирэхгүй гэсэн үг биз дээ?”

Учрыг нь асуухад найзаас нь гашуудлын ил захидал ирсэн байв.

- “Аан, тийн тийн. Надад ч бас ирсэн” гэж бусад хүүхдүүд ч ам зэрэгцэн хэлэв.

Хүүхдүүд маань жил бүр шинэ жилийн ил захидал ирэхийг тэсэн ядан хүлээдэг юм. 1 сарын 1-нд ирсэн бүх захидлыг хувааж аваад хүн хүнд нь хуваарилна. “Дахиад өвөөд ирлээ” гэх мэт ярингаа тэр дундаас өөрт нь ирсэн захиаг олмогц учиргүй баярлан дахин дахин харж уншина. Одоо бодоход би ч гэсэн хүүхэд байхдаа шинэ жилийн ил захидал ирэхийг хүлээж тэвчилгүй, гэрт ирж буй зочдыг утгах тоолондоо шуудангийн хайрцгаа байн байн шалгадаг байж билээ.

- “Харин тийм ээ, ээж нь ч гэсэн ойлгож байна” гэхэд хүүхдүүд:

- “Үнэхээр тийм биз дээ? Дээр нь бас шинэ жилийн сугалаа ч байхгүй болно гэсэн үг шүү дээ”

Үүсгэн байгуулагч амьд байх үеэс л манай гэрт жил болгон маш олон шинэ жилийн ил захидал ирдэг байсан боловч сугалаагаар нь нэг л удаа шуудангийн марк хожиж байсан юм. “Энэ сугалаа нь ер нь хэнд ч таардаггүй юм биш үү?” гэж ярьж байсан нэг жил аавд ирсэн ил захидлын дугаар хонжвортой байв. Тэр нь бүр хонжворын 1-р байрны шагнал болох том зурагт байсан юм. Тэр жилээс хойш бид ирсэн ил захидал бүрийн дугаарыг сайн тулгаж шалгадаг болсон юм. Тийм байхад шинэ жилээр ил захидал хүлээж авахгүй байна гэдэг үнэхээр харамсалтай зүйл.

- “Нээрэн тийм шүү. Гэхдээ ээжийнх нь ээлж ирэхэд тэгэх хэрэггүй шүү. Гашуудаж суулгүй ил захидлаа явуулдгаараа явуулж, авдгаараа авч, шинэ жилээ сайхан өнгөрүүлэх хэрэгтэй шүү” гэж намайг хэлтэл бүгд хэсэг чимээгүй болцгоов. Эцэг эх гэдэг үр хүүхдээ ямар ч үед ч сайхан



Нивано Коошёо

Рисшо Косей Кайгийн ерөнхийлөгч Нивано Ничикогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн. Хуулч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараагаар тус нийгэмлэгийн удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа нийгэмлэгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагатай хамтран ажиллах тал дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн тус нийгэмлэгийн удаах ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

хөгжилтэй байгаасай гэж боддог. Ингэж бодоод хэлтэл уур амьсгал нэг биш болж, бүгд хөшиж орхив.

- “Надад ерөөсөө гашуудлын үед шинэ жилийн ил захидал хэрэггүй ээ. Шинэ жилийг ч тэмдэглэхгүй” гэж хэн нэгэн нь хэлэхэд уур амьсгал жоохон зөөлөрч эхлэв. Ямар үед гашуудлын ил захидал явуулах хэрэгтэй болохыг гэнэт ойлгосон бололтой байв.

- “Би ч гэсэн гашуудлын ил захидал явуулнаа” гэж нэг охин маань хэлэхэд хүү маань “Ээж ээ, та битгий эмээ болоорой” гэж хэлээд намайг тэврэв.

Ийнхүү ёстой сонин хэлбэрээр ээждээ хайртайгаа илэрхийлсэн нь сонирхолтой санагдсан хэдий ч, хүүхдүүд маань миний төлөө гашуудлын ил захидал явуулна гэдэг үнэхээр сайхан зүйл гэж бодогдож, сэтгэл хөдлөв.

- “Миний хүүхдүүд, баярлалаа. Гашуудлын ил захидал гэдэг хүмүүс өөд болсон хүнийг хичнээн их хайрлаж, хүндэлж явдаг сэтгэлээ дамжуулах утгатай юм шүү дээ.”

- “Тэгвэл ил захидал дээр бас зүрх, од наагаад хөөрхөн чимэглэвэл яасан юм бэ?”

- “Тэр чинь сайхан санаа байна шүү.”

Ийнхүү тэр үдэш гэр бүлийнхэн маань хэзээ нэгэн цагт илгээх гашуудлын ил захидлын тухай ярьж суусан юм.





Сургаалын замд хөтлөн оруулсан номын багш, шавийн харилцаа



Хүмүүсийг сургаалын замд хөтлөн оруулах нь гишүүдийн тоог нэмэхийн төлөө зүйл биш. Сургаалын замд хөтлөн оруулахын тулд эхлээд өөрийгөө засаж, сургаалыг хүндлэн тахиж хэрэгтэй.

Сургаалд хөтлөн оруулах хүнээ өөрийн толь гэж үзэж, тэр хүнээс суралцах нь чухал. Өөрийгөө мартаж, тэр хүний төлөө гэсэн чин сэтгэл хэрэгтэй. Ингэсний үр дүнд хүмүүсийг сургаалын замд оруулж чадна. Өөрөөр хэлбэл, бурханаас нэг хүн хүлээн авч хариуцаж байна гэсэн үг юм. Энэ мөчөөс сургаалаар холбогдсон номын багш, шавийн харилцаа эхэлж, харилцан бие биенээ хөгжүүлж явах үүрэгтэй болох юм.

Гэтэл сургаалын замд хөтлөн оруулснаар нормоо биелүүлж, бүх юм дууслаа гэж боддог хүмүүс ч байдаг. Энэ бол үнэхээр харамсалтай зүйл. Үнэндээ бол чухам сургаалд хөтлөн оруулсан тэр мөчөөс л гол ажил эхэлдэг юм.

Хувь заяагаар холбогдсон номын багш, шавь хоёр бие биенээ өөрийн толь мэт үзэн, бие биенээ хөгжүүлэх үүрэгтэй. Ингэж бие биенээ хөгжүүлэхгүй бол зөв хүмүүс цуглардаг “Зөв хүмүүсийн холбоо” биш зүгээр л жирийн хүмүүсийн цуглаан болж орхино. Өнөөгийн нийгэмд юмыг дутуу хагас хийх явдал их гарах болсон ч, шашны ертөнцийн хувьд энэ нь байж боломгүй зүйл. Номын багш, шавь болсноос хойших харилцаа ч гэсэн чухал юм.

Үүсгэн Байгуулагчийн Үг 6, 88-89х.

Косей кайг дэлхийн тавцанд гаргах залуус

Жил бүр гадаад салбарын залуу гишүүд Гакүрин сургуулийн гадаад оюутны курст элсэн ордог. 2 жилийн дотор Япон хэлний мэдлэг нь эрчимтэй сайжирч, Косей Кайгийн сургаал, уламжлалыг тэд бие, сэтгээрээ өөрийн болгоно.

Нэгэн залуу баяр хөөр, хатуу итгэлтэйгээр ийнхүү хэлсэн юм. “Косей кайгийн сургаал манай эх оронд заавал дэлгэрнэ. Би энэ сургаалыг хичээнгүйлэн түгээх болно.”

Гадаад оюутан бүрийн дотор суулгасан сургаалын үр ийнхүү цэцгээ дэлгэрүүлж байна. Тэд эх орондоо очоод сургаалын үр цацаж, хязгааргүй олон үзэсгэлэнтэй цэцэг дэлгэрүүлэх нь гарцаагүй. Ирээдүйд хязгааргүй олон бодисадва нар газраас хөөрөн гарч ирэх нь нүдэнд үзэгдэнэ.

Энэ сард манай нийгэмлэг үүсгэн байгуулагдсаны 75 жилийн ойн баяр тохиож байна. Цаашид Рисшо Косей кай дэлхийд буддизмыг дэлгэрүүлэх хөдөлгөөнийг улам өргөн хүрээтэй явуулна. Гакүрин сургуулийн гадаад оюутнуудын ачаар энэхүү зорилт улам бат боллоо.

РКК, Олон Улсын Хэлтсийн дарга
Мизүтани Шёоко

Ерөнхийлөгч Нивано Ничико доктор Сарож Кумар Чаудориг хүлээн авч уулзав

Ерөнхийлөгч Нивано Ничико 1 сарын 29-нд Энэтхэгийн Дэли Их Сургуулийн багш, Япон хэлний судлаач Сарожи Кумар Чаудори докторыг эхнэр Бани хатагтайн хамт Хооринкакү танхимд хүлээн авч уулзлаа. Тус уулзалтанд Ерөнхийлөгчийн гэргий Ёшиэ, Олон Улсын Хэлтсийн дэд захирал Хагивара Юкимаса, туслах захирал Ёшида Ко-Ичиро нар оролцсон байна.

Доктор Чаудори нь Дэли Их Сургууль, Токиогийн Гадаад Хэлний Их Сургууль, Айчи Гакүсэн Их Сургуульд багшилдаг ба Япон хэл, Зүүн Азийн хэл соёлын нэрт судлаач юм. 2011 оны 6 сард тус нийгэмлэгийн урилгаар Японд ирж, ноднин жилийн 12 сар хүртэл “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ын Бэнгал хэлний орчуулгыг хийж дуусгасан юм.

Тэрээр орчуулгын ажлын тухай ярихдаа “Надад боломж олгож өгсөнд маш их талархаж байна” гэж хэлжээ. Түүнчлэн “Бэнгал хэл дээр гарах уг ном нь нийгэмлэгийн гишүүд төдийгүй бусад буддын шашин судлаачид, эрдэмтдийн анхаарлыг ч татна” гэв.

Мөн Санскрит хэл ба бусад хэлний холбоо, Энэтхэг ба Японы буддизмын ойлголтын нийтлэг ба ялгаатай тал зэрэг судалгааныхаа ажлын үр дүнгийн талаар

ярьжээ. Ерөнхийлөгч Нивано докторт талархал илэрхийлэхийн зэрэгцээ яриаг сонирхон сонссон байна.


Бэнгал хэлийг хэрэглэдэг орон болох Бангладеш, Энэтхэгийн Баруун Бэнгал мужийн гишүүдийн хүсэн хүлээж байсан “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ын Бэнгал хэл дээрх орчуулга ийнхүү дуусаж, одоо эх бэлтгэлийн ажил явагдаж байгаа ба энэ ондоо багтааж хэвлэлтэнд гаргах төлөвлөгөөтэй байна.



Доктор Чаудори (баруун тал) Ерөнхийлөгч Ниванотой ярилцаж байгаа нь

Рисшо Косей кай байгууллагын тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон Хамтран үндэслэгч Наганүма Мёоко нарын санаачлагаар үүсгэн байгуулагдсан. Манай байгууллага нь “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ын сургаалыг гол номлолоо болгосон эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл бурхан багшийн сургаалыг гэр, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлэх замаар дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикогийн удирдлага дор сургаал түгээх үйлсэд зүтгэж, шашны бусад байгууллага болон дэлхийн олон орны хүмүүстэй гар барин, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.



SHAN-ZAI Vol. 90 (March 2013)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс, Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail: shanzai@kosei-kai.or.jp
Ахлах редактор: Мизүтани Шооко, Редактор: Накамүра Эцүко, Орчуулсан: Ш.Жаргалмаа, Ж.Гэрэлтуяа
Хэвлэлийн баг: Ёшида Кэй-ичиро, Мацүока Шихо, Мизүмо Кацүтоши, Күдо Юкино, Это Маюми, Сүзүки Саюри, Канао Эрико, Макино Эми, Ногава Юриэ, Накаяма Ёшихиро

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Португал, Тай, Монгол зэрэг 11 улсын хэл дээр тогтмол хэвлэгдэн гарч байна.
※Санал хүсэлт, сэтгэгдэл байвал дээрх хаягаар холбоо барина уу.
※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэстэй холбоо барина уу.

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2013

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@rkina.org http://www.rkina.org

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
http://www.buddhismtampabay.org/

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4265

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net http://www.rkina.org/losangeles.html

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
http://www.rkina.org/sanantonio.html

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: info@rksf.org http://www.rksf.org

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com
http://www.buddhistLearningCenter.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Lotus Buddhist Circle

San Mateo, CA 94401, U.S.A.
Tel: 1-650-200-3755
e-mail: LotusBuddhist@gmail.com
http://www.LotusBuddhistCircle.com

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com http://rk-ny.org/

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami4838@aol.com http://home.earthlink.net/~rkchi/

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1571 Race Street, Denver, Colorado 80206, U.S.A.
Tel: 1-303-810-3638

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.
http://www.rkina-dayton.com/

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304
e-mail: risho@terra.com.br http://www.rkk.org.br

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-4724-8862

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjehng District, Taipei City 100
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Jilung

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Korean Rissho Kosei-kai of Masan

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong,
Special Administrative Region of the People's Republic of China
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar,
Mongolia

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France

Rissho Kosei-kai of Sydney**International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Sugunami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibt-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House No.467, Road No-8 (East), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel & Fax: 94-11-2826367

Rissho Kosei-kai of Polonnaruwa**Rissho Kosei-kai of Habarana**

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle**Rissho Kosei-kai of Kandy-wattegama**

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

Branches under the South Asia Division**Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel: 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of West Delhi

A-139 Ganesh Nagar, Tilak Nagar
New Delhi-110018, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Rissho Kosei-kai of Singapore**Rissho Kosei-kai of Phnom Penh**

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Other Groups**Rissho Kosei-kai Friends in Shanghai**

1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,
Shanghai 200081 China